



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 1/125

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5.“в”, 29.1.6.“ж”, “л”, 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2021 оны 45, 78 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18, 20, 21 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/221 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн халдварын тархалтын улбар шар түвшинд шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан нарт үүрэг болгосугай.

1.1. Дүүргийн нутаг дэвгэрт хязгаарлалт тогтоогоогүй худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа 07:00-22:00 цаг хүртэл хугацаанд явагдаж байгаа байдалд хяналт тавьж, хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 23:00-06:00 цагийн хооронд (эмнэлгийн тусламж үйлчилгээ, буяны үйлчилгээ, шөнийн нислэг, инженерийн байгууламж хот нийтийн аж ахуйн ажил, тусгай зориулалтын техник хэрэгслээс бусад) бүрэн хязгаарлан, нийтийн хэв журам сахиулж ажиллахыг дүүрэг дэх Цагдаагийн газар /дэд хурандаа П.Очбадрах/-т;

1.2. Иргэдийг Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх дархлаажуулалт, цар тахлын халдварын эрт илрүүлгийн сорьцын ПГУ-ын шинжилгээнд хамруулах ажлыг эрчимжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төв /Д.Тамир/-д;

1.3. Нийтийн зориулалттай орон сууцны байр, орц, хонгил, цахилгаан шат, зоорийн давхар, техникийн өрөө, гудамж, талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Цэнд-Очир/-т;

1.4. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг “Халдварын эсрэг хамтдаа” сэдэвт нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалах, дүүргийн Онцгой комиссоос Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр зохион байгуулан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албанд;

1.5. Дүүргийн 11, 20, 23, 28 дугаар хорооны нутаг дэвсгэрийн алслагдсан бүсэд мал аж ахуй, газар тариалан болон бусад чиглэлийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг иргэдийг тухайн хороонд оршин суух хаягийг үндэслэн нэвтрүүлэхийг дүүрэг дэх Цагдаагийн газар /дэд хурандаа П.Очбадрах/-т;

2. Байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулж, бусад албан хаагчид болон 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийг цахимаар ажиллах боломжоор хангахыг Засаг даргын Тамгын газар, дүүргийн Засаг даргын харьяа газар, хэлтэс, албадын дарга нарт зөвлөсүгэй.

3. Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Онцгой байдлын хэлтэс /хурандаа Д.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын нэгдүгээр орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.БАЯРМӨНХ